

Эрхэм хүндэт Нийлүүлэгчид/Хамтран ажиллагсад аа,

Энэхүү товхимолоор 2011 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн Оюу Толгой ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлагдаж, 2012 оны 11 сард шинэчлэгдсэн Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаанд баримтлах зарчим болон холбогдох бодлогын баримт бичгүүдийг нэгтгэн хүргэж байгааг хүлээн авна уу.



**Г.Батсүх**

Төлөөлөн Удирдах  
Зөвлөлийн дарга



**Камерон Макрей**

Ерөнхийлөгч  
бөгөөд  
Гүйцэтгэх Ерөнхий  
Захирал



**Айвен Велла**

Дэд Ерөнхийлөгч  
Хангамж, Дэд  
Бүтцийн Хөгжил

## **АГУУЛГА**

- 1. Оюу Толгой ХХК –ийн Худалдан авах ажиллагаанд баримтлах зарчим .....3**
- 2. Оюу Толгой ХХК–ийн Худалдан авалт хариуцсан ажилтны Ёс Зүйн Дүрэм ..29**
- 3. Нийлүүлэгчийн Гэрээ Хэрэгжүүлэх Чадварын Тухай .....39**
- 4. Стратегийн ач холбогдол бүхий гадаадын нийлүүлэгчидтэй хамтран ажиллах тухай бодлого .....47**
- 5. Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай .....51**
- 6. Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай бодлого .....59**

# 1

## Оюу Толгой ХХК -ийн Худалдан авах ажиллагаанд баримтлах зарчим

### ТАНИЛЦУУЛГА 5

1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ДУГААР 5
2. ЗОРИЛГО 5
3. ХАМРАХ ХҮРЭЭ 7
4. МӨРДӨЖ ЭХЛЭХ ХУГАЦАА 8
5. БҮРЭН ЭРХ, УДИРДЛАГА 8

### БОДЛОГО 9

#### 1. БИД ДОТООД ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИДТЭЙГЭЭ ХЭРХЭН ХАРИЛЦДАГ ТУХАЙ 9

- 1.1. Засаглал
- 1.2. Эх үүсвэрийг тогтоох
- 1.3. Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн үүрэг
- 1.4. Оюу Толгой ХХК-ийн эцсийн хэрэглэгчийн хэлтсийн үүрэг
- 1.5. Худалдан авалт
- 1.6. Дотогш чиглэлтэй нийлүүлэлтийн сүлжээ
- 1.7. Хөрөнгийн удирдлагын стратеги
- 1.8. Эрсдлийн удирдлага

#### 2. БИД НИЙЛҮҮЛЭГЧИДТЭЙ ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ТУХАЙ 12

- 2.1. Нийлүүлэгчдэд тавигдах чадварын шаардлага
- 2.2. Цахим худалдаа
- 2.3. Тендерийн үйл ажиллагаа
- 2.4. Дотоодын нийлүүлэгчдийг хөгжүүлэх
- 2.5. Шалгарсан оролцогчтой/нийлүүлэгчтэй гэрээ байгуулах
- 2.6. Худалдан авах захиалга болон Гэрээ
- 2.7. Үйлчилгээнд тавих шаардлага
- 2.8. Төлбөр хийх
- 2.9. Гэрээний хяналт
- 2.10. Нийлүүлэгчид Оюу Толгой ХХК-ийн нэр, лого, худалдааны тэмдгийг ашиглах

**3. БИДНИЙ АЖЛЫН БАЙР 16**

- 3.1. Аюулгүй ажиллагаа
- 3.2. Мансууруулах бодис, согтууруулах ундааны нөлөө
- 3.3. Эрүүл мэнд
- 3.4. Ажил эрхлэлт

**4. БАЙГАЛ ОРЧИН, ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ХҮНИЙ ЭРХ 18**

- 4.1. Байгаль орчин
- 4.2. Тогтвортой хөгжил
- 4.3. Хүний эрх

**5. БИЗНЕСИЙГ ШУДАРГААР ЯВУУЛАХ 20**

- 5.1. Өрсөлдөөн ба монопольчлолын эсрэг
- 5.2. Авилга, хээл хахууль
- 5.3. Бэлэг дурсгал, дайллага
- 5.4. Нууцлал
- 5.5. Сонирхлын зөрчил
- 5.6. Олон улсын бизнес

**6. ХАВСРАЛТ 22**

## Танилцуулга

### 1. Бодлогын баримт бичгийн дугаар


Энэхүү баримт бичгийг **ХААБ-00: Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагаанд баримтлах зарчим** гэж нэрлэнэ.

### 2. Зорилго

Энэхүү бодлогын баримт бичигт Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагаа, түүнийг зохион байгуулах дотоод арга аргачлал, Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж болон худалдан авах ажиллагаанд оролцож буй дотоод үйлчлүүлэгчдэд тавигдах шаардлага, талуудын хүлээх үүрэг, Оюу Толгой ХХК-ийн худалдан авалт хариуцсан ажилтнууд болон нийлүүлэгч, гүйцэтгэгч нарт тавигдах шаардлагын талаар тоймлон оруулав.

Зураг 1-д харуулснаар, Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагааны зарчмууд нь үг ажиллагааг удирдан чиглүүлэх талаар баримтлах үндсэн 8 бодлогын үндэс суурь нь бөгөөд дагалдах дүрэм журмыг тус компанийн Худалдан авах ажиллагаа хариуцсан удирдлагын баг боловсруулж хэрэгжүүлнэ.

ЗУРАГ 1. Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагааг удирдан зохицуулах үндсэн бодлогын баримт бичгүүд



### ХААБ 01: Хөрөнгө зарцуулалтыг төрөлжүүлэх, ангилах тухай бодлого

Энэхүү бодлогын баримт бичигт Оюу Толгой ХХК-ийн хөрөнгийн зарцуулалтыг төрөлжүүлэх, ангилах талаар тодорхой чиглэл, удирдамжийг тусгасан болно. Ялангуяа, Оюу Толгой ХХК нь өөрийн худалдан авах бараа, үйлчилгээг хэрэгцээ шаардлага, зориулалтаар нь хэрхэн "төрөлжүүлж ангилдаг" талаар, түүнд хуваарилах хөрөнгийн зарцуулалтыг хэрхэн тодорхойлох талаар болон тухайн ангилалд нь буюу үйл ажиллагааны ач холбогдол, нөлөөлөл, эрсдэл,

үнэлэмж зэрэгт тулгуурлан худалдан авах ажиллагааг зохион байгуулах арга аргачлалыг хэрхэн ялгаж тодорхойлох талаар заасан болно. Мөн түүнчлэн, энэхүү ангилалыг хийснээрээ худалдан авагч байгууллагад хэрхэн яаж нөлөөлж буй болон хариуцсан бүтцийн зохион байгуулалт, хүлээх хариуцлагын талаар төдийгүй худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг (нөөцийг татах болон зах зээлийн төлөв байдлын) хэрхэн хийж гүйцэтгэдэг, мөн Монгол улсын дотоодын нийлүүлэгчдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дотоодоос худалдан авах боломжийг тодорхойлоход Оюу Толгой ХХК нь хөрөнгө зарцуулалтын ангилал, төрлийг хэрхэн хэрэглэж ажиллах талаар тус баримт бичигт заасан болно. Дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт бичгийг ХААБ-01: Хөрөнгө зарцуулалтыг төрөлжүүлэх, ангилах тухай бодлогоос үзнэ үү.

### **ХААБ 02: Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын тухай бодлого**

Оюу Толгой ХХК-д үйлчилгээ үзүүлэх өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад оролцохоор бүртгүүлэх хүсэлтэй нийлүүлэгчдэд Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэхэд энэхүү бодлого нь хамаарна. Тухайн шаардлагатай үйлчилгээний цар хүрээ, мөн чанараас буюу Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагаанд нөлөөлөх байдал, ач холбогдлын зэрэглэл зэрэг шинж байдлаас нь хамааран гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлдэг. Чадварыг үнэлэх ажлын хүрээнд нийлүүлэгчдийг Оюу Толгой ХХК-ийн стандарт, шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж байгааг нь шалгаж үздэг бөгөөд энэ нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин (ЭМААБО)-ы болоод өөр бусад чадварын шаардлагад тулхуу чиглэсэн байдаг. Дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт бичгийг ХААБ 02: Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын тухай бодлогоос үзнэ үү.

### **ХААБ03: Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай бодлого (Шийдвэр гаргах дараалал)**

Энэхүү бодлогын баримт бичигт Оюу Толгой ХХК-ийн хувьд худалдан авах ажиллагааг зохион байгуулах нөхцөлийн талаар тайлбарласан байдаг. Үүнд: өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын босго үнэ, байгууллага дахь удирдлагын холбогдох түвшинд хөрөнгийн зарцуулалтыг батлах, хянах үүрэг хариуцлагыг тогтооох болон эрх мэдлийг төлөөлөн удирдах талаар тодорхойлсон болно. Дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт бичгийг ХААБ 03: Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай бодлого (Шийдвэр гаргах дараалал)-оос үзнэ үү.

### **ХААБ 04: Шууд худалдан авалтын тухай бодлого**

Энэхүү бодлогын баримт бичигт Оюу Толгой ХХК-ийн тухайн худалдан авалтын хувьд өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын стандарт журмаас зөвшөөрөгдөх хэмжээнд зөрүүтэй байгааг хүлээн зөвшөөрсөн ба энэ нь шууд худалдан авалтыг зүй зохистой байдлаар зохион байгуулах шаардлагыг зүй ёсоор бий болгож байгаа тохиолдолд түүнийг хэрхэн зохион байгуулах талаар удирдамж, зааварчилгааг тогтоосон болно. Ялангуяа, энэ бодлого нь шууд худалдан авалтыг ямар нөхцөлд хэрхэн зохион байгуулах, энэхүү шийдвэрийг хэн гаргах талаар тодорхой ойлголтыг өгнө. Дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт бичгийг ХААБ 04: Шууд худалдан авалтын тухай бодлогоос үзнэ үү.

### **ХААБ 05: Стратегийн ач холбогдол бүхий гадаадын нийлүүлэгчидтэй хамтран ажиллах тухай бодлого**

Стратегийн ач холбогдол бүхий гадаадын нийлүүлэгчидтэй хамтран ажиллах тухай тус бодлогын хүрээнд орон нутаг, дотоодод өгөх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллаж буй гадаадын томоохон нийлүүлэгчдэд чиглэгдсэн хөтөлбөрийг тодорхойлсон болно. Ялангуяа, Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу нийлүүлэгчийн хүлээх үүрэг, тухайн хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Оюу Толгой ХХК-иас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, мөн нийлүүлэгчдийн үнэлгээ болон, уг үүргийн биелэлтэд гүйцэтгэлийн хяналт шинжилгээ хийх талаар тодорхой ойлголтыг өгсөн болно. Дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт бичгийг ХААБ 05: Стратегийн ач холбогдол бүхий гадаадын нийлүүлэгчидтэй хамтран ажиллах тухай бодлогоос үзнэ үү.

### **ХААБ 06: Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай бодлого**

Тус бодлого нь Оюу Толгой ХХК-ийн Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу Өмнөговийн нийлүүлэгч болохыг тодорхойлох эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлтийг тогтоон уг шаардлагыг хангасан Өмнөговийн нийлүүлэгчдэд эхний ээлжинд давуу эрх олгоход чиглэгдсэн болно. Түүнчлэн, тус бодлогод Өмнөговийн нийлүүлэгчдийн хөгжлийг дэмжих зорилгоор боловсруулсан Оюу Толгой ХХК-ийн төсөл хөтөлбөрүүдийг тайлбарласан болно. Дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт бичгийг ХААБ 06: Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай бодлогоос үзнэ үү.

### **ХААБ 07: Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай бодлого**

Тус бодлогын хүрээнд өсөн дэвжиж буй Монгол Улсын үндэсний нийлүүлэгчидтэй хамтран ажиллах Оюу Толгой ХХК-ийн үүрэг хариуцлагыг баталгаажуулж, үндэсний нийлүүлэгч болохыг тодорхойлох эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлтийг тогтоосон болно. Түүнчлэн энэхүү бодлогоор үндэсний нийлүүлэгчдийг хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилго бүхий Оюу Толгой ХХК-ийн зүгээс авч хэрэгжүүлэх санаачилга, арга хэмжээг тодорхойлсон. Дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт бичгийг ХААБ 07: Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай бодлогоос үзнэ үү.

### **ХААБ 08: Худалдан авалт хариуцсан ажилтны Ёс зүйн дүрэм**

Энэхүү бодлогоор ашиг сонирхлын зөрчил, бэлэг дурсгал, хөндлөнгийн гуравдагч этгээдээс өгөх урамшуулал, нууцлал, ажил хэргийн найрсаг харилцаа, хээл хахууль, авилга зэрэг асуудлаар Оюу Толгой ХХК-ийн байр суурийн талаар тодорхой ойлголтыг өгөх худалдан авалт хариуцсан ажилтан, гүйцэтгэгч нарт зориулсан удирдамж/зааварчилгааг өгсөн болно.

## **3. Хамрах хүрээ**

Тус бодлогын баримт бичгийг дараах хүмүүс даган мөрдөнө. Үүнд:

- Оюу Толгой ХХК-ийн бүх ажилтнууд;

- Оюу Толгой ХХК-ийн бүх нийлүүлэгч нар;
- Оюу Толгой ХХК-ийн бүх гүйцэтгэгч нар болно.

Энэхүү бодлогын баримт бичгийг Рио Тинто-ийн эзэмшдэг, Худалдан авах ажиллагаанд баримтлах зарчимд тулгуурлан боловсруулав.

#### **4. Мөрдөж эхлэх хугацаа**

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогыг 2012 оны 11-р сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

#### **5. Бүрэн эрх, удирдлага**

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогын баримт бичгийг Оюу Толгой ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2012 оны 11-р сарын 20-ны өдөр батлав.

Энэхүү баримт бичгийг жил бүр эсхүл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хянан засварлана.

Оюу Толгой ХХК-ийн Хангамж, Дэд бүтцийн хөгжил хариуцсан Дэд ерөнхийлөгч нь тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хариуцна. Энэхүү бодлогод өөрчлөлт оруулах аливаа санал хүсэлтийг дээрх албан тушаалтанд гаргах бөгөөд тэрээр зохих ёсоор хянан, батална.



## Бодлого

### 1. Бид дотоод үйлчлүүлэгчидтэйгээ хэрхэн харилцдаг тухай

Худалдан авах ажиллагааг өөрийн үйлчлүүлэгчдийнхээ өмнөөс зөв явуулах үүднээс олон төрлийн дэмжлэг бүхий арга хэмжээ, нөхцлийг хэрэгжүүлдэг. Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй байхыг бид үйл ажиллагааныхаа үндсэн зарчим болгодог. Дэлгэрэнгүй мэдээллийг 15 дугаар хуудаснаас үзнэ үү.

#### 1.1. Засаглал

- Оюу Толгой ХХК-ийн мөнгөн сангаас зарцуулалтыг хийхдээ холбогдох бизнесийн нэгж эсхүл санхүүгийн албанд баталсны үндсэн дээр худалдааны зохих журмын дагуу зөвшөөрөл олгож гүйцэтгэн бүртгэл хөтөлдөг.
- Бид Оюу Толгой ХХК-ийн бодлого, стандартуудыг дагаж мөрддөг.
- Нийлүүлэгч нь хүчин төгөлдөр “худалдан авах захиалга”-ыг хүлээн авсан тохиолдолд л үйл ажиллагаагаа эхлүүлнэ.
- Бид худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг тогтмол үнэлэн дүгнэж үйлчлүүлэгчиддээ тухай бүр тайлагнадаг. Тэдний хэрэгцээг хангахын тулд бид шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийг сайжруулах, засч залруулах арга хэмжээг авдаг.
- Оюу Толгой ХХК нь өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үр дүнд боломжит хамгийн сайн үнэ цэнийг олж авахыг зорьдог бөгөөд үүнд холбогдох бүхий л хүчин зүйлс болох аюулгүй ажиллагаа, чанар, тогтвортой байдал, хүргэлт, техникийн үзүүлэлтүүд, үнэ, байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөлөл, тогтвортой хөгжил зэрэг асуудлыг сайтар харгалзан үздэг болно.

#### 1.2. Эх үүсвэрийг тогтоох

Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагааны бодлогын хүрээнд Оюу Толгой ХХК-ийн зүгээс бараа, үйлчилгээний эх үүсвэрийг тогтооход тавигдах наад захын шаардлагыг гаргаж ирнэ.

#### 1.3. Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн үүрэг

Энэхүү бодлогын хүрээнд бид дараах үйл ажиллагааг мөрдлөг болгоно. Үүнд:

- Зохистой эх үүсвэрийг тогтоох бодлого боловсруулах зорилгоор Оюу Толгой ХХК-ийн эцсийн хэрэглэгчийн хэлтэстэй зөвшилцсөний үндсэн дээр тэдний хэрэгцээ, худалдан авч буй бараа, үйлчилгээнээс хүлээж буй үр дүнгийн талаар бүрэн ойлголт авах;
- Бид бизнесийн үйл ажиллагааны шаардлагыг хангах богино хугацааны болон урт хугацааны алсын хараа бүхий стратеги төлөвлөгөөний бодлогыг боловсруулдаг. Бид “нэг удаа”-ийн бараа үйлчилгээ худалдан авахаас нийлүүлэгч гадна олон жилийн эсхүл урт хугацааны стратегийн гэрээг нийлүүлэгчидтэй байгуулан ажилладаг;

- Бид зах зээлд гаргах эх үүсвэрийг тогтооход тохиромжтой стратегийг боловсруулах талаар Оюу Толгой ХХК-ийн эцсийн хэрэглэгчийн хэлтэстэй зөвшилцсөний дараа нийлүүлэгчидтэй ажиллаж эхэлдэг;
- Бид нийлүүлэгчдээс ирүүлсэн хариулт дээр үндэслэн Оюу Толгой ХХК-ийн бизнесийн нэгжүүдийн өмнөөс нийлүүлэлтийн гэрээг санаачлан эхлүүлж, хэлэлцээ хийдэг;
- Бид нийлүүлэлтийн гэрээг байгуулах нэгдсэн журмыг баталж мөрддөг ба гэрээний стандарт нөхцлүүдийг баримталдаг;
- Бид гэрээний удирдлага, зохион байгуулалтын талаар нийлүүлэгчидтэй үүсэх арилжааны харилцааг удирдан зохицуулдаг;
  1. Гэрээний удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааны хэсэг болох дор дурдсан үүргийг шаардлагатай тохиолдолд бид хүлээнэ. Үүнд: нийлүүлэгчидтэй хийх уулзалтыг болон үнийн хяналтын талаар ажил санаачлах;
  2. гэрээнд хамааралтай үнийн индекс-үүдэд хяналт тавьж, шинэчлэх;
  3. гэрээнд заасан тодорхой хугацаа бүрт нийлүүлэгчийн гүйцэтгэлийг хянах;
  4. даатгалын гэрчилгээг цуглуулж, хадгалах;
  5. гэрээ дуусгавар болох хугацааг хянах;
  6. гэрээний мэдээллийн санг хөтлөх;

#### 1.4. Оюу Толгой ХХК-ийн эцсийн хэрэглэгчийн хэлтсийн үүрэг

Бараа үйлчилгээний эх үүсвэрийг тогтоох дэмжлэг үзүүлэх үүднээс бизнесийн нэгжүүд дор дурьдсан үүргийг хүлээнэ. Үүнд:

- худалдан авах ажиллагааг зохих журмын дагуу дэс дараатайгаар явуулахад шаардагдах хангалттай хугацааг тооцоолох;
- ажлын цар хүрээ болон тавигдах дэлгэрэнгүй шаардлагыг тодорхойлохдоо орон нутгийн эх үүсвэрийг тогтоох болон тогтвортой хөгжлийн асуудлыг харгалзан үзэж багтаасан байх;
- шаардлагатай бол аливаа шинэ гэрээг боловсруулахад холбогдолтой баримтжуулсан эрсдлийн судалгааг ирүүлэх;
- санал болгож буй нийлүүлэгчдийн жагсаалт (Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж нь боломжит нийлүүлэгчдийг шаардлагатай гэж үзвэл нэмж урьж оролцуулна);
- өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг явуулах боломжгүй тохиолдолд бүрэн гүйцэд бөглөсөн, зохих зөвшөөрөл бүхий 'Шууд худалдан авах хүсэлт'-ийг ирүүлэх;
- үйлчлүүлэгчийн тусгайлан заасан эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны холбогдолтой аливаа нөхцөл стандарт, дүрэм журам болон орон нутгийн зүгээс нийлүүлэгчдэд тавигдах шаардлагууд;
- гэрээ байгуулах эрх олгох шалгууруудыг тодорхойлох болон
- төлбөрийг цагт нь барагдуулах зорилгоор нэхэмжлэлийг хүлээн авах болон батлах ажлыг цаг хугацаанд нь хийх зэрэг болно.

Мөн бизнесийн нэгж нь ажлын талбай дахь үйлчилгээний гүйцэтгэлд (Гүйцэтгэгчийн удирдлага гэх мэт) хяналт тавьж, хариуцах үүрэгтэй. Үүнд дор дурдсан үүргийг ойлгох ба мөн үүгээр хязгаарлагдахгүй:

- Гүйцэтгэгч, үндсэн ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
- Байгаль орчин, орон нутагт үзүүлэх нөлөөллийн талаар хяналт тавьж ажиллах;
- Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлтэй холбоотой бүхий л асуудалд хяналт тавьж, удирдан зохицуулах;
- Ажилласан цаг, зардал, үр дүн, төслийн биелэлтийг шалгаж, батлах;

### 1.5. Худалдан авалт

#### Бараа материалын бүртгэл

Бараа материалын бүртгэлд орсон барааны хувьд нийлүүлэгчидтэй урьдчилан гэрээ байгуулах ба давтан нийлүүлэлтийн захиалгыг нөөцийн түвшнийг бүрдүүлэх доод хэмжээнд үндэслэн байгууллагын нөөцийн төлөвлөлтийн (БНТ) системээс автоматаар хийдэг. Оюу Толгой ХХК-ийн бизнесийн нэгжүүдийн ажилтнууд нь давтан нийлүүлэлтийн захиалгыг байгууллагын нөөцийн төлөвлөлтийн (БНТ) системд оруулж хүсэлт гаргана.

#### Үйлчилгээ болон бараа материалын бүртгэлд ороогүй бараа

Бүртгэлд ороогүй бараа, үйлчилгээний жагсаалт гарган бүртгэж болно.

Түүнчлэн, үйлчилгээ болон нөөцийн бүртгэлд хамрагдаагүй барааг хэрэглэгч худалдан авах тухай хүсэлт гаргаснаар Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж тухайн бараа, үйлчилгээний эх үүсвэрийг тогтоон худалдан авалтын захиалга бүрдүүлнэ. Нийлүүлэгч нь хугацаандаа, заасан тоо хэмжээгээр нийлүүлж байгаа эсэхэд Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж захиалгын дагуу хяналт тавина.

### 1.6. Дотогш чиглэлтэй нийлүүлэлтийн сүлжээ

Дотогш чиглэлтэй нийлүүлэлтийн сүлжээ нь худалдан авмагцаа төлбөр хийх боломжийг хангаж өгдөг.

Үйл ажиллагааг төлөвлөх, эх үүсвэрийг тогтоох, нийлүүлэгчидтэй харилцах болон агуулах, бараа материалын бүртгэл хөтлөх, тээвэрлэх, хог хаягдлын зохион байгуулалт, ажлын талбайгаас гадуур засвар үйлчилгээ хийлгэх ба үндсэн мэдээлэл бэлтгэх зэрэг үйл ажиллагаанд сонирхлын бүлгүүдийг татан оролцуулах, зохицуулах замаар бид дотогш чиглэлтэй нийлүүлэлтийн сүлжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг. Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж нь шаардлагатай үед дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:

- Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагаанд тохиромжтой нийлүүлэлтийн сүлжээний стандартыг тодорхойлох;
- нийлүүлэлтийн сүлжээний гүйцэтгэл, биелэлтийг үнэлэх, тайлагнах;
- бараа материалыг нөөцлөн хадгалах, бүртгэл хөтлөх стандарт журам ба үйл явцад чанарын хяналтын аудит, шалгалт хийх;
- нийлүүлэлтийн сүлжээний сонголтын тоо хэмжээг тодорхойлох зорилгоор Өмчлөлийн нийт зардлын (ӨНЗ) талаар зөвлөгөө өгөх;

- нийлүүлэлтийн сүлжээний чадавхийн эрсдлийн үнэлгээг бүс нутаг, бизнесийн нэгж эсхүл нэр төрлөөр нь гаргах;
- нийлүүлэлтийн сүлжээг сайжруулах аливаа санал санаачилгыг дэмжих, ивээн тэтгэх;
- гадны эх үүсвэрээс ашиглаж буй агуулах болон хангамжийн үйлчилгээний байгууллагуудтай харилцах, удирдан чиглүүлэх;

## 1.7. Хөрөнгийн удирдлагын стратеги

Бид Оюу Толгой ХХК-ийн бусад бизнесийн нэгжүүдтэй хамтран, нийлүүлэлтийн сүлжээнд тулгуурлан хөрөнгийн удирдлагын стратеги/бодлогоо боловсруулахад нь Оюу Толгой ХХК-ийн эцсийн хэрэглэгчийн хэлтэст туслалцаа үзүүлдэг.

Үүний үр дүнд хэрэглээний шаардлагад томоохон өөрчлөлт гарахаар бол Оюу Толгой ХХК-ийн эцсийн хэрэглэгчийн хэлтсээс Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжид урьдчилан мэдэгдэх боломжтой.

## 1.8. Эрсдлийн удирдлага

Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж нь их хэмжээний зарцуулалт болон нэн чухал үйл ажиллагааг удирдан явуулах үүрэг хариуцлагыг хүлээдэг.

Бид нийлүүлэлтийн үнэ, аюулгүй ажиллагаа, гэрээний нөхцлүүдийн (мөн үүгээр хязгаарлагдахгүй) эрсдлийг бууруулахад тохиромжтой стратеги боловсруулан хэрэгжүүлэхээр Оюу Толгой ХХК-ийн холбогдох бизнесийн нэгжүүдтэй хамтран ажилладаг.

## 2. Бид нийлүүлэгчидтэй хэрхэн ажилладаг тухай

Оюу Толгой ХХК-ийн амжилтанд аюулгүй, үр бүтээлч, шинийг санаачлагч нийлүүлэгчид нь стратегийн ач холбогдолтой байдаг. Шударга, өрсөлдөөнт зах зээлийг бий болгохын тулд бид бүх боломжит нийлүүлэгчдийг ижил шалгуураар дүгнэж, сонголт хийдэг.

Оюу Толгой ХХК нь бүх нийлүүлэгчдэд дор дурдсан шаардлагыг тавьдаг. Үүнд:

- Бидний бизнесийн дараах зорилтуудад нийцсэн байх. Үүнд:
  1. ажлын байранд хүн бэртэх болон осол эндэгдэл огт гаргахгүй байх, улмаар хүний амь эрсдэх явдал гаргахгүйн төлөө ажиллах
  2. үнэ цэнийг нэмэгдүүлэх
  3. үйл ажиллагаа, бүтээмжийг дээшлүүлэх болон эрчим хүч хэмнэх
  4. хог хаягдлыг багасгах/ таслан зогсоох
  5. өөрийн үйлчлүүлэгчдийн Өмчлөлийн нийт зардлыг (ӨНЗ) багасгах
- санхүүгийн хувьд бүрэн чадвартай, бие даасан байх
- бараа бүтээгдэхүүний шууд үйлдвэрлэгч буюу эсхүл албан ёсны эрх бүхий төлөөлөгч /дистрибьютер-ийн аль нь болох
- цахим гүйлгээ хийх чадвартай байх (цахим гүйлгээ хийх дэд бүтэцгүй орон нутгийн нийлүүлэгчдэд энэ нь хамаарахгүй)
- бараа материал болон үйлчилгээг ханган нийлүүлэх чадвартай боловсон хүчинтэй байх
- ЭМАББО-ны зохих шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах ба чанарын баталгаажуулах системийг мөрдөх

- Оюу Толгой ХХК-оос тавих шаардлага, нөхцлүүдийн дагуу нийлүүлэлт хийх
- шударга өрсөлдөөнийг дэмжих бодлого явуулах, зохих хууль дүрэм, стандарт, журмыг дагаж мөрдөх, авилга өгөх, авахыг хориглох ба эдгээрийг дагаж мөрдөх зэрэг болно.

Бид аюулгүй байдлыг чанд сахидаг, эдийн засгийн хөгжил, нийгмийн сайн сайхны төлөө тэмүүлдэг, байгаль орчныг хамгаалдаг, хүчтэй засаглалыг дэмждэг нийлүүлэгчдийг үнэлж тууштай хамтран ажиллана.

Бид бараа үйлчилгээ ханган нийлүүлэх эх үүсвэрийг орон нутгаас нь олж ашиглах нь тухайн орон нутаг, улс орны нийгэм, эдийн засагт томоохон ач холбогдолтой болохыг ойлгож байна. Иймээс бид орон нутгийн нийлүүлэгчидтэй хамтран ажиллахыг, тэдэнд Оюу Толгой ХХК-тай хамтран ажиллаж ханган нийлүүлэлт хийх бололцоо олгохыг эрмэлздэг. Дэлгэрэнгүй мэдээллийг 14 дүгээр хуудаснаас үзнэ үү. Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж нь нийлүүлэгчдээс дор дурдсан нөхцлийг бүрэн хангаж ажиллахыг шаардах болно. Үүнд:

- Нийлүүлэлтийн явцад үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж, нийлүүлэгч Оюу Толгой ХХК-ийг худалдааны эрсдлээс хамгаалах;
- Нийлүүлэлтийн сүлжээний давуу талыг бий болгох;
- Тогтвортой хангамж, нийлүүлэлтийг дэмжих ;

## 2.1. Нийлүүлэгчдэд тавигдах чадварын шаардлага

Нийлүүлэгчдийн чадварын шаардлага нь бидний хэрэглэгчдэд очих бараа материал, үйлчилгээний чанарыг хангах, байгаль орчинд аль болох бага хохирол учруулах, хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангаж байгаа эсэхийг тодорхойлоход нэн чухал үүрэгтэй юм.

Оюу Толгой ХХК-ийн бараа материал болон үйлчилгээнд тавигдах стандарт, шаардлагыг хангаж ажиллаж буйгаа баримт жишээгээр харуулж нотлох нь нийлүүлэгчид тавигдах чадварын шаардлагын нэг үзүүлэлт юм. Үүнд дараах дүгнэлтүүд орно: ЭМАББО, чанарын удирдлага ба чанарыг байнга дээшлүүлэхэд анхаарч буй байдал, санхүүгийн чадавхи, ёс зүй, харъяа орон нутагт оруулах хувь нэмэр, үр өгөөж (аж ахуйн нэгжүүдийг оролцоог сайжруулж буй байдал), хүний нөөцийн удирдлага, эрхэлдэг үйлчилгээ ба түүний талаарх мэдээлэл, хууль эрх зүй болон мэдээллийн найдвартай байдал гэх мэт зүйлс хамаарах ба мөн үүгээр хязгаарлагдахгүй.

Бүх нийлүүлэгчид нь Оюу Толгой ХХК-тай хамтран ажиллаж эхлэхээс өмнө тавигдах шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд хамтран ажиллахад тавигдах журамтай зохих ёсны дагуу танилцсан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ХААБ 02: Нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварын талаар баримтлах бодлогоос үзнэ үү.

## 2.2. Цахим худалдаа

Оюу Толгой ХХК нь шаардлагатай тохиолдолд худалдан авмагцаа төлбөр тооцоо автоматаар хийх ажиллагаа, худалдан авах захиалгыг солилцох, нэхэмжлэл, бусад гүйлгээний баримт бичгийг интернетэд суурилсан түгээмэл хэрэглэгддэг цахим худалдан авалтын хэлбэрээр шилжүүлэх зэрэг цахим

худалдааны стратегийг ашиглахыг эрмэлздэг. Оюу Толгой ХХК-тай бизнесийн үйл ажиллагааг энэхүү цахим худалдааны хэлбэрээр явуулах боломжтой аливаа нийлүүлэгчийг хөхүүлэн дэмжинэ.

### 2.3. Тендерийн үйл ажиллагаа

Оюу Толгой ХХК нь цахим хэрэгслийг нийлүүлэгчидтэй харилцах, мэдээлэл солилцох чухал арга зам гэж үздэг. Бид эдгээр хэрэгслийг өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаа, тэр дундаа тендер шалгаруулалтын үйл ажиллагаандаа өргөнөөр ашигладаг.

Гэрээ хэрэгжүүлэх чадвар бүхий Оюу Толгой ХХК-ийн зүгээс тавьсан шалгуурт тэнцэх боломжтой нийлүүлэгчдийг бид тендерт оролцохыг урьдаг.

Тендерт шалгаруулалтад оролцохыг хүсч буй боломжит чадвар бүхий нийлүүлэгч нь Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагааны онлайн системд бүртгүүлэх шаардлагатай. Ийнхүү бүртгүүлснээр дор дурьдсан мэдээлэл, баримт бичгийг авах боломжтой болно. Үүнд:

- Гэрээний маягт болон тендер ирүүлэхэд анхаарах нөхцлүүд;
- Бизнесийн зүгээс тавигдах холбогдох шаардлагууд ба тухайн нийлүүлэх бараа материал, үйлчилгээнд тавигдах техникийн үзүүлэлт, стандартын шаардлагууд
- Тендер шалгаруулалт хэрхэн явагдах талаар зааварчилгаа зэрэг болно.

Бид нийлүүлэгчдийн ирүүлсэн мэдээллийн нууцлалыг чанд хадгалж, сонгон шалгаруулалтад оролцож буй бүх нийлүүлэгчдэд тэгш, шударга ханддаг.

### 2.4. Дотоодын нийлүүлэгчдийг хөгжүүлэх

Найдвартай, тогтвортой, зардал багатай хангамжийн сүлжээг бий болгохын тулд Оюу Толгой ХХК нь дотоодын нийлүүлэгчдийг хөгжүүлэх, сайжруулахад, түүнчлэн хөгжлийн талаар тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулна. Тус хөтөлбөр, ажил хэрэгт дараах санаачилгууд багтах ба мөн үүгээр хязгаарлагдахгүй. Тухайлбал:

- Нийлүүлэгчдийн санхүүжилтэд туслах зорилгоор дотоодын болон орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан бичил зээлийн хөтөлбөр;
- Бизнесээ өргөжүүлэн тэлэхэд нь дотоодын болон орон нутгийн нийлүүлэгчдэд тууштай дэмжлэг үзүүлэхээр Өмнөговь аймагт “Орон нутгийн Нийлүүлэгчийг хөгжүүлэх төв” ажиллуулах;
- Өмнөговь, Даланзадгадын нийлүүлэгчдийг сургах, хөгжүүлэх, мэргэшил, ур чадварыг нь сайжруулах хөтөлбөр;
- Нийлүүлэгчдийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Тодорхой нийлүүлэгчдийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах;
- Нийлүүлэгчдийг танилцуулах хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлж, холбогдох шагнал гардуулах ёслолын ажиллагааг тууштай зохион байгуулах.

Дээрхи санаа санаачилга нь гагцхүү дотоодын нийлүүлэгчдэд зориулсан бөгөөд тэдгээрийн Оюу Толгой ХХК-ийн өрсөлдөөнт тендер шалгаруулалтад амжилттай оролцуулахад, оролцоог сайжруулахад чиглэгдсэн юм.

Харин гадаадын нийлүүлэгчдийн хувьд үүнтэй ижил төстэй санаачилга, дэмжлэг үзүүлдэггүй болно. Дотоодын нийлүүлэгчдийг хөгжүүлэх санаачилгын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт бичгийг ХААБ 06: Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх талаар баримтлах бодлого, ХААБ 07: Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх талаар баримтлах бодлогоос үзнэ үү.

## **2.5. Шалгарсан оролцогчтой/нийлүүлэгчтэй гэрээ байгуулах**

Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж нь байгууллагын дотоод эцсийн хэрэглэгчийн холбогдох хэлтэстэйгээ зөвшилцсөний үндсэн дээр тендер шалгаруулалтад ирүүлсэн саналуудыг олон төрлийн хүчин зүйл, шалгуурт тулгуурлан хянан үзээд аль саналыг хүлээн авах эсэх тухай шийдвэр гаргана.

Зөвхөн дор дурьдсан шаардлагыг хангасан нийлүүлэгчидтэй гэрээ байгуулна. Үүнд:

- Оюу Толгой ХХК-ийн ЭМАББО-ны стандартыг хангасан байх;
- үйлчилгээний хувьд, Оюу Толгой ХХК-ийн журамд заасан мэргэшсэн байх шаардлагыг хангасан байх;
- тендер шалгаруулалтын бүхий л шалгуурыг хангасан байх;
- дотоодын үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, тэдний стандартын шаардлагыг хангасан байх;
- сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтэд нийцсэн хамгийн сайн тендер ирүүлсэн байх;

энэхүү баримт бичигт заасан шаардлага нөхцлийг хангасан байх зэрэг болно. Үнэ цэнийг бий болгож, найдвартай, ашигтай ханган нийлүүлэлтийн нөөцийг бүрдүүлэх болон биднийг тогтвортой хөгжлийн зорилтуудаа биелүүлэхэд хувь нэмрээ оруулах зэргээр Оюу Толгой ХХК-тай хамтран ажиллахад бүрэн бэлтгэгдсэн нийлүүлэгчийг бид өндрөөр үнэлнэ.

## **2.6. Худалдан авах захиалга болон Гэрээ**

Зөвхөн Оюу Толгой ХХК-ийн бизнесийн нэгжээс худалдан авах хүчинтэй захиалга буюу гэрээг нийлүүлэгчид олгосон тохиолдолд уг нийлүүлэгч нь бараа материал, үйлчилгээг ханган нийлүүлнэ. Оюу Толгой ХХК нь тухайн худалдан авах захиалга, гэрээний нөхцлийн дагуу бүрэн гүйцэт, хүчин төгөлдөр нэхэмжлэх ирүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид төлбөр төлөхөөс татгалзах эрхтэй.

## **2.7. Үйлчилгээнд тавих шаардлага**

Нийлүүлэгчид нь бараа материал, үйлчилгээний бүрэн бүтэн байдлыг шалгаж, хугацаанд нь багтаан, худалдан авах захиалгын зохих шаардлага, нөхцлийн дагуу нийлүүлэх ёстой.

Нийлүүлэгч нь тохиролцсон нийлүүлэлтийн хугацаа, тоо хэмжээ, байршилд өөрчлөлт гарсан бол гэрээний нөхцөлд хязгаарлагдахгүйгээр Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжид нэн даруй мэдэгдэнэ.

## 2.8. Төлбөр хийх

Худалдан авах захиалга ба үйлчилгээний шаардлагыг ханган биелүүлсэн тохиолдолд төлбөрийг гэрээгээр харилцан тохиролцсон нөхцөл, хугацаанаас хоцруулалгүй гүйцэтгэнэ.

## 2.9. Гэрээний хяналт

Гэрээний гүйцэтгэлийг хянах, цаашид сайжруулах боломжийг судлах, мөн гэрээнд шийдэгдээгүй үлдсэн асуудлыг хэлэлцэх зэрэг зорилгоор Оюу Толгой ХХК-ийн холбогдох бизнесийн нэгж болон Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн төлөөлөгчид хүсэлт гарган гэрээний хэрэгжилтийн хугацаанд нийлүүлэгчидтэй уулзаж болно. Эдгээр уулзалтанд гэрээт нийлүүлэгч нь өөрийн зохих албан ёсны төлөөлөгчдийг оролцуулах ёстой.

## 2.10. Нийлүүлэгчид Оюу Толгой ХХК-ийн нэр, лого, худалдааны тэмдгийг ашиглах

Холбогдох хууль дүрмэнд зааснаас бусад, эсхүл гэрээ хэлэлцээрээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд гэрээт болон цаашид хамтран ажиллах нийлүүлэгчид нь Оюу Толгой ХХК-ийн нэр, лого, барааны тэмдгийг зөвшөөрөлгүйгээр ашиглах, Оюу Толгой ХХК-иас урьдчилж албан ёсны зөвшөөрөл авалгүйгээр гэрээний агуулгатай холбогдолтой мэдээллийн талаар нийтэд зарлах, мөн Оюу Толгой ХХК-тай хамтран ажиллаж байгаа тухайгаа олон нийтэд мэдээлэх ёсгүй.

# 3. Бидний ажлын байр

Бидний хүлээсэн үүрэг амлалт, тэдгээртэй холбоотой баримт бичиг, ажилтнуудад тавигдах зан төлөв, харилцааны шаардлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доор орууллаа.

## 3.1. Аюулгүй ажиллагаа

Бид гэнэтийн осол, гэмтлээс ангид ажлын байрыг бий болгохын төлөө ажилладаг. Бидний зорилго бол осол гэмтэл огт гаргахгүй байх явдал юм. Бидний үйл ажиллагаа явуулж буй газар бүрт Оюу Толгой ХХК-ийн аюулгүйн стандарт, систем, журмыг бүрэн дүүрэн хатуу мөрдөнө. Ажлын байранд осол гэмтэл гаргуулахгүй байлгахад хүн бүрийн хүчин зүтгэл чухал үүрэгтэй.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Бид хамтран ажиллаж буй бизнес эрхлэгчдээс эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг эрхэмлэн сахихыг хүснэ. Бид хамтран ажилладаг гэрээт нийлүүлэгчдээс Оюу Толгой ХХК-ийн бизнесийн нэгжүүдийн аюулгүй ажиллагааны шаардлагыг дагаж мөрдөхийг юуны өмнө шаарддаг.

Нийлүүлэгчид дор дурьдсан шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- бараа бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд эрсдэл учруулахгүй байх нөхцлийг хангах;



- байгууллагын хэмжээнд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдлагыг даган мөрдөж, ажлын байранд гэмтэж бэртэх, өвчлөх эрсдлийг арилгах;
- аудит, хяналт шалгалтыг тогтмол хийж дотоодын болон гадаадын чанар шалгагчдаар аюулгүй ажиллагааны журмыг хэрхэн мөрдөж ажиллаж байгаа тал дээр шалгуулж дүгнэлт тайлан гаргуулдаг байх;

### **3.2. Мансууруулах бодис, согтууруулах ундааны нөлөө**

Оюу Толгой ХХК-ийн ажлын байранд хуулиар хорьсон мансууруулах бодис биедээ авч явах буюу хэрэглэх, согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөөнд ажиллахыг хатуу хориглоно.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Оюу Толгой ХХК-ийн төслийн талбайд ажил гүйцэтгэж буй эсхүл төслийн талбайд ажил гүйцэтгэх болсон нийлүүлэгчид нь Оюу Толгой ХХК-ийн ажлын талбайд байх хугацаандаа мансууруулах бодис, согтууруулах ундааг хориглосон тухай Оюу Толгой ХХК-ийн төслийн талбайд тавигддаг стандартыг даган мөрдөх ёстой.

### **3.3. Эрүүл мэнд**

Бид хамтран ажилладаг хүмүүсийнхээ эрүүл мэнд, сайн сайхныг хамгаалахыг эрмэлздэг.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Гэрээт нийлүүлэгчид Оюу Толгой ХХК-ийн бизнесийн нэгжүүдэд хэрэгжүүлдэг эрүүл мэндийн бүх шаардлагыг дагаж мөрдөх ёстой. Гэрээт нийлүүлэгчид ажилчдынхаа эрүүл мэндийн талаар хариуцлагатай хөтөлбөр боловсруулж ажлын байранд өвчлөл гаргуулахгүй байх тал дээр хатуу анхаарч үүнийг бодит ажил хэрэг болгох ёстой.

### **3.4. Ажил эрхлэлт**

Бид өөрийн ажилчид болон манай компаний үйл ажиллагаанд оролцож буй бизнесийн түншүүдийнхээ эрх ашиг, нэр хүндийг хүндэтгэдэг. Хэрэв ажилтнууд нь ноцтой асуудлыг сөхөн тавих, эсхүл бусдын буруу үйл ажиллагааг илтгэхийг хүсвэл СПИК АУТ/ЧӨЛӨӨТЭЙ ЯРЬ/ хэмээх санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх хөтөлбөртэй холбогдож болно. СПИК АУТ хөтөлбөрийн тухай мэдээлэл, мөн орон нутгийн ажилтнуудтай холбогдох утасны дугаар зэргийг Оюу Толгой ХХК-ийн бүх ажлын байрнаас авч болно.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Бид гэрээт нийлүүлэгчдийг холбогдох хууль дүрэм, стандарт, журмуудыг дагаж мөрдөхийг шаарддаг ба хүчээр, боолчлон, мөн хүүхдээр хөдөлмөр эрхлүүлэхийг хориглож, эсэргүүцдэг. Бид Оюу Толгой ХХК-ийн энэхүү журамтай адил зарчмыг баримталдаг, хүчирхийллээс ангид нийлүүлэгчийг өндрөөр үнэлнэ.

## 4.

# Байгал орчин, тогтвортой хөгжил ба хүний эрх

Бидний хүлээсэн үүрэг амлалт, тэдгээртэй холбоотой баримт бичиг, ажилтнуудад тавигдах зан төлөв, харилцааны шаардлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доор орууллаа.

### 4.1. Байгаль орчин

Байгаль орчныг хамгаалах ажиллагаа, бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх нөлөөг багасгах нь бидний бизнесийн амжилтанд нэн чухал үүрэгтэй. Бид байгаль орчинд учрах эрсдлийг Оюу Толгой ХХК-ийн стандарт, стратеги, зорилт, зохион байгуулалтаараа удирдан хянадаг.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Оюу Толгой ХХК-ийн бизнесийн нэгжүүдийн мөрддөг байгаль орчны зохих шаардлагуудыг зайлшгүй мөрдөх ёстой. Бид гэрээт нийлүүлэгчдийг багаар бодоход дор дурдсан асуудлаар тууштай байр суурь баримтлахыг хүсдэг. Үүнд:

- байгаль орчны хариуцлагатай удирдлага;
- байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг багасгах;
- хог хаягдлыг багасгах;
- нөөцийг хариуцлагатай ашиглах;
- бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх нөлөөг багасгах;
- хүлэмжийн хий зэрэг цаг уурын нөлөөллийг багасгах;
- байгаль орчны эрсдэлд сэрэмжтэй хандах;
- байгаль орчны талаар хариуцлагатай хандах явдлыг түлхүү анхаарах, байгаль орчинд ээлтэй технологийг бий болгох, түгээх явдлыг хөхүүлэн дэмжих;
- биологийн төрөл зүйлийн тархалтыг зөв зохицуулж , хамгаалах;
- усны тогтвортой удирдлага зэрэг болно.

Бид байгаль орчинд учруулсан хор хөнөөлийг байнга нөхөн сэргээх зарчмыг эрхэмлэдэг.

### 4.2. Тогтвортой хөгжил

Бид аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, нийгмийн сайн сайхан, байгаль орчны хамгаалал, хүчтэй засаглал дээр тулгуурласан тогтвортой нийлүүлэлтийн сүлжээг бий болгохын төлөө зорьж ажилладаг.

Оюу Толгой ХХК-ийн хувьд ирээдүйн нөөц хэрэгцээг эрсдэлд учруулалгүйгээр одоогийн хэрэгцээг хангах, салбар нэгжүүддээ, мөн орон нутгийн хийгээд дэлхийн ард иргэдтэй ухаалгаар харьцаж үйл ажиллагаагаа явуулах бодлого, журам боловсруулах, түүнчлэн бидний хийж бүтээсэн зүйл бүхэн хүмүүст сайн сайхан ирээдүйг авчрахын төлөө ажиллах юм гэдгийг бид тогтвортой хөгжил хэмээн тодорхойлдог.

Бид өөрийн ажилтан ажилчид болон гэрээт нийлүүлэгчдийн мэдээлэлд үндэслэсэн зөв сонголт хийж, худалдан авалт хийх, ханган нийлүүлэх, эх

үүсвэрийг тогтоох зэрэг асуудалд уян хатан хандах, мөн бидний дотоод үйлчлүүлэгчдийн тогтоосон орон нутгийн ард иргэдийг дэмжих стратегийг хэрэгжүүлж ажиллахыг эрмэлзэнэ.

Ийм хандлага нь бидэнд дор дурьдсан боломжуудыг олгоно. Үүнд:

- эрсдлийг зөв дүгнэж, удирдах;
- Оюу Толгой ХХК болон түүний нийлүүлэгчид, хэрэглэгчдэд бизнесийн сонголтыг бий болгох;
- зардлыг багасгах;
- шилдэг ажилчдыг компанидаа татаж, сургах, хөгжүүлэх;
- шинэ зах зээл, нөөц бололцоог нээх;
- Оюу Толгой ХХК-ийн эцсийн хэрэглэгчийн хэлтсүүдийг илүү сайн бүтээгдэхүүнээр хангах;
- үйл ажиллагаа явуулж буй иргэдийн бүлгийн урт хугацааны хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг болно.

Нийлүүлэгчид нь ХААБ 06: Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх талаар баримтлах бодлого, ХААБ 07: Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх талаар бидний баримтлах бодлоготой танилцаж, энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг авах хэрэгтэй.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Нийлүүлэгчид нь тухайн улсын хууль, бизнесийн нэгжид тавигдах шаардлагыг дагаж мөрдөх ёстой. Тогтвортой хөгжлийн зарчмыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж, Оюу Толгой ХХК-ийг тогтвортой хөгжлийн зорилгодоо хүрэхэд нь тусалж дэмжих нийлүүлэгчдийг бид өндрөөр үнэлэх болно.

Бид нийлүүлэгчдээс байгаль орчны стандартыг мөрдөж, нутгийн ард иргэдтэй хариуцлагатай харилцааг бий болгохыг шаардана. Бидний үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн тогтвортой хөгжилд эерэг нөлөө үзүүлэх бизнесийн харилцааг бий болгох нийлүүлэгчийг бид өндрөөр үнэлэх болно.

### **4.3. Хүний эрх**

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын дагуу бид хүний эрхийг дэмжиж хүндэтгэдэг бөгөөд хүний эрхийг зөрчсөн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх идэвхтэй бодлого баримталдаг.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Нийлүүлэгчид нь хүний үндсэн эрх, нэр хүнд, түүний дотор амьд явах эрх, эрх чөлөө, нэр төр, хувь хүний аюулгүй байдал, боолчлол болон хэрцгийлэлээс ангид байх, хууль, үндсэн хуулийн дор тэгш эрх эдлэх явдлыг хүндэтгэдэг бодлого хэрэгжүүлэх ёстой. Бид нийлүүлэгчдээс дээр дурдсаны дагуу хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх механизмтай байхыг шаарддаг.

## 5. Бизнесийг шударгаар явуулах

Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн бизнесийг шударгаар явуулах байр суурь, бидний үүрэг амлалт, холбогдох баримт бичгийн талаар дэлгэрэнгүй заасан Оюу Толгой ХХК-ийн ХААБ 08: Худалдан авалт хариуцсан ажилтны Ёс зүйн дүрэм-ийн хамтаар уншиж танилцах шаардлагатай.

### 5.1. Өрсөлдөөн ба монопольчлолын эсрэг

Оюу Толгой ХХК нь чөлөөт, шударга өрсөлдөөний зарчмыг баримталж, үйл ажиллагаагаа ил тод явуулна.

Ажилтнууд, гэрээлэн гүйцэтгэгчид нь хэрэгжүүлэхээр зэхэж буй арга хэмжээнийхээ талаар эргэлзэж байвал Оюу Толгой ХХК-ийн хуульчид хандана.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Бид нийлүүлэгчид болон тэдний ажилтан ажиллагсдыг монопольчлолын эсрэг, шударга бус өрсөлдөөн ба худалдааны тухай зохих хууль тогтоомж, дүрэм журам, захирамжуудыг дагаж мөрдөхийг шаардана.

### 5.2. Авилга, хээл хахууль

Оюу Толгой ХХК нь хээл хахууль ба авилгын бүх хэлбэрийг хориглодог ба ялангуяа бизнесээ авч үлдэх эсхүл шударга бусаар өөрт давуу байдал бий болгох, удирдах зорилгоор буюу бизнесийн ёс зүйд үл нийцэх зүй бус арга хэрэглэн, шууд болон шууд бусаар ‘тусламж үзүүлсэн төлбөр’ хүлээн авахыг хатуу хориглоно.

Зуучлалын бүх зохицуулалт болон хандив тусламжийг зөвхөн Оюу Толгой ХХК-ийн ХААБ 08: Худалдан авалт хариуцсан ажилтны Ёс зүйн дүрэм-ийн стандартын дагуу зохицуулах ёстой.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Бид нийлүүлэгчдийг Оюу Толгой ХХК-ийн ХААБ 08: Худалдан авалт хариуцсан ажилтны Ёс зүйн дүрэм-ийг хүндэтгэн, даган мөрдөхийг шаардана.

### 5.3. Бэлэг дурсгал, дайллага

Бэлэг дурсгал, дайллагыг шан харамж болгон, эсхүл давуу эрхийн байдал үүсгэх зорилгоор өгөх буюу хүлээн авахыг хориглоно. Зарим тодорхой нөхцөлд багахан хэмжээний бэлэг дурсгал буюу дайллагыг өгөх ба хүлээн авч болно. Хүлээн зөвшөөрч болох бэлэг дурсгал ба дайллагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг ХААБ 08: Худалдан авалт хариуцсан ажилтны Ёс зүйн дүрэм-ээс үзэж танилцана уу.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Нийлүүлэгчдийг хүлээн зөвшөөрөгдөх боломжгүй бэлэг дурсгал, дайллагыг Оюу Толгой ХХК-ийн ажилтнуудад санал болгохыг хориглох ба Оюу Толгой ХХК-ийн ХААБ 08: Худалдан авалт хариуцсан ажилтны Ёс зүйн дүрэм-ийг хүндэтгэн, дагаж мөрдөхийг шаардана.

## 5.4. Нууцлал

Бид Оюу Толгой ХХК-ийн мэдээллийн нууцлалыг, бусад этгээд, түүний дотор хэрэглэгчид болон нийлүүлэгчдийн бидэнд итгэн мэдээлсэн аливаа мэдээллийн нууцлалыг үргэлжид чандлан хадгалах ёстой.

Бид нийлүүлэгчдийн тухай бүх мэдээлэл, түүний дотор үнэлгээ, зураг төсөл, ноу-хау зэргийг чанд нууцлах ба үүнийг зөвхөн зохих зориулалтын дагуу хэрэглэнэ. Мэдээллийг Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн баримт бичгийн стандартын дагуу найдвартай хамгаалалтад байлгана.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Оюу Толгой ХХК-ийн бүх нийлүүлэгчид нь бизнесийн үйл ажиллагаа явуулахдаа Оюу Толгой ХХК-ийн оюуны өмчийн эрхийг хамгаалан хүндэтгэх шаардлагатай. Бизнесийн үйл ажиллагаа явуулахад зориулан аливаа нийлүүлэгчид шууд буюу шууд бусаар ашиглуулахаар олгосон Оюу Толгой ХХК-ийн аливаа оюуны өмчийг зөвхөн тухайн бизнесийн зорилгод л ашиглах ёстой.

Мөн түүнчлэн гэрээт нийлүүлэгчид нь Оюу Толгой ХХК-ийн аливаа оюуны өмчийг найдвартай хамгаалалтын доор, аюулгүй газар, нууцлалыг чандлан сахиж хадгалах ба Оюу Толгой ХХК-ийн албан ёсны зөвшөөрлийн тусгай бичиггүйгээр ямар нэгэн хөндлөнгийн этгээд, түүний дотор туслан гүйцэтгэгч нарт задруулах ёсгүй.

Нийлүүлэгч нь өөрийн байгууллагын тухай нууцлал бүхий мэдээллийг Оюу Толгой ХХК-д өгөх бол, уг мэдээллийг дамжуулахаас өмнө Оюу Толгой ХХК-д энэ тухай албан ёсоор мэдээлж, нууцлалын гэрээ буюу эсхүл түүнтэй төстэй хэлцэл үйлдэх хэрэгтэй.

## 5.5. Сонирхлын зөрчил

Бид бүгд хувь хүний аливаа үйл ажиллагаа, ашиг сонирхол нь Оюу Толгой ХХК-ийн өмнө хүлээх бидний хариуцлагатай зөрчилдөхгүй байх талаар баталгаа гаргах ёстой. Ашиг сонирхлын зөрчлийн аливаа шинж тэмдэг ч илрэх ёсгүй. Сонирхлын зөрчилд дор дурьдсан зүйлсийг хамааруулах ба энэ нь мөн үүгээр зөвхөн хязгаарлагдахгүй. Үүнд:

- нийлүүлэгч, үйлчлүүлэгч болон өрсөлдөгч нартай бизнесийн харилцаанаас гадуур албан бус харилцаа, сонирхол үүсгэх;
- төрөл садан, найз нөхөд болон тэдний эзэмшдэг аливаа нэгэн компанитай Оюу Толгой ХХК-ийн нэрийн өмнөөс бизнесийн харилцаа үүсгэх ;
- төрөл садан юм уу, хайр сэтгэлийн холбоотой хүний хувьд нөлөө үзүүлэх, ажлын үнэлгээнд хяналт тавих болон цалин урамшуулал олгох эрх мэдэл бүхий албан тушаал эрхлэх;
- Оюу Толгой ХХК-тай ямар нэгэн бизнесийн харилцаанд орж буй, эсхүл хийхээр төлөвлөж буй хувь хүн ба албан байгууллагаас бага хэмжээний бэлэг дурсгал, дайллагаас хэтэрсэн хувийн урамшуулал, төлбөрийг шууд ба шууд бус хэлбэрээр авах зэрэг болно.

Сонирхлын зөрчлийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг ХААБ 08: Худалдан авалт хариуцсан ажилтны Ёс зүйн дүрэм-ээс үзнэ үү.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Манай нийлүүлэгчид ХААБ 08: Худалдан авалт хариуцсан ажилтны Ёс зүйн дүрэм-тэй танилцаж, дэлгэрэнгүй мэдээлэл авч, холбогдох баримт бичигтэй танилцах ёстой.

## 5.6. Олон улсын бизнес

Бид дэлхийн олон улс оронд бизнес эрхэлдэг бөгөөд тухайн улсынхаа хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрддөг. Эдгээр нь улс орон бүрийн хувьд хоорондоо харилцан адилгүй байх ба түүнчлэн эрсдэл нь ч мөн адил өөр өөр байдаг.

*Бид нийлүүлэгчдээс юуг шаарддаг вэ?*

Нийлүүлэгчид нь Оюу Толгой ХХК-ийн бизнесийн нэгжүүдэд бараа материал, үйлчилгээ ханган нийлүүлэхдээ холбогдох бүхий л хууль тогтоомж, дүрэм, журмыг даган мөрдөж, хяналт тавих ёстой.

## 6. Хавсралт

Дараах нэр томьёог Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагааны бодлогын баримт бичгүүдэд ашиглах бөгөөд энэ нь Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагаанд баримтлах зарчмын салшгүй хэсэг болно. Үүнд:

- **Төлөөлөгчийн гэрээ:** Гадаадын нийлүүлэгчийг тухайн бүс нутагт төлөөлж ажиллах зорилгоор дотоодын нийлүүлэгчтэй тогтоосон харилцаа.
- **Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө:** Байгууллагын хэмжээнд шаардлагатай бараа, үйлчилгээний ашиглалтын урсгал зардлыг тусгасан байна.
- **Дадлагажуулах сургалт:** Онол, дадлагыг хослуулан ур чадвар дамжуулах.
- **Шийдвэр гаргах дараалал (Зарцуулалтын зөвшөөрөл олгох матриц):** Тендер шалгаруулалтын жагсаалт, гэрээ байгуулах, бараа материалын тохируулга хийх болон бусад төрлийн санхүүгийн гүйлгээг батлах/зөвшөөрөл олгох шийдвэрийг гаргах эрх бүхий Оюу Толгой ХХК-ийн холбогдох албан тушаалын нэр, тухайн эрхийн хэмжээ хязгаарыг харуулсан хүснэгт. Уг матрицыг FI-01 Оюу Толгой ХХК, Шийдвэр гаргах дараалал (Зарцуулалтын зөвшөөрөл олгох матриц)-аас үзнэ үү.
- **Өрсөлдөөнт сонгон шалгаруулалт:** Зарцуулах мөнгөн дүн буюу босго үнээс хамааран сонгох худалдан авах ажиллагааны арга бөгөөд шаардлага хангасан 3-аас доошгүй нийлүүлэгч тухайн бараа, үйлчилгээний төрөл, ангилал дахь зах зээл дээр өрсөлдөх шаардлагатай.
- **Байгууллагын нөөцийг төлөвлөх систем:** Оюу Толгой ХХК-ийн бүх хэлтсийг нэгтгэсэн бизнесийн үйл ажиллагааны системийн програм хангамж

- **Сонирхолоо илэрхийлсэн захидал:** Байгууллагаас зарласан урилгын дагуу тухайн худалдан авахаар зорьж буй барааг нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх сонирхолоо тухайн зах зээлээс илэрхийлсэн байдал.
- **Гэрээний ерөнхий нөхцөл:** Тодорхой бараа, үйлчилгээний тухайд хийгдэх гэрээний хууль эрх зүйн нөхцөлийг тогтоосон Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ. Уг нөхцөлд Нийлүүлэгч болон Оюу Толгой ХХК-ийн харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тусгадаг.
- **Хамтарсан түншлэл:** хувь нийлүүлэх замаар тодорхой хугацаанд шинэ аж ахуйн нэгж, шинэ хөрөнгө бий болгохоор талуудын тохирсон бизнесийн тохиролцоо/зөвшилцөл.
- **Дотоодын/орон нутгийн:** Энэхүү бодлогын баримт бичгийн дагуу, дотоодын нийлүүлэгч гэдэг нь Өмнөговь аймгийн бүс нутагт байрладаг орон нутгийн болоод үндэсний бусад нийлүүлэгчдийг тус тус хамаарна.
- **Нийлүүлэгчдийн нэгдсэн жагсаалт:** Оюу Толгой ХХК-ийн хөтөлдөг, худалдан авалтын төрөл бүрт харгалзах гэрээ хэрэгжүүлэх чадвар бүхий нийлүүлэгчдийн мэдээллийн сан.
- **Нийлүүлэлтийн Мастер Гэрээ:** Урьдчилан тогтоосон үнээр (үнийн жагсаалт, төлбөрийн хуваарь болон хүү зэргийг) гүйлгээ хийхээр тохирч, Оюу Толгой ХХК ба нийлүүлэгчдийн хооронд байгуулсан гэрээ.
- **Харилцан ойлголцлын санамж бичиг:** Хоёр буюу олон талт хэлэлцээрийн баримт бичиг. Үүнд талууд санал нэгдсэн байдлаа илэрхийлж, харилцан тохиролцсон үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлдог.
- **Дотоодын бизнес эрхлэгчдэд зориулсан зөвлөн сургах хөтөлбөр:** Оюу Толгой ХХК-ийн ханган нийлүүлэлтийн стратегийн түншүүд нь дотоодын аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх тухай Харилцан ойлголцлын санамж бичигт орсон үүрэг амлалт.
- **Бичил зээлийн хөтөлбөр:** Өмнөговь аймгийн бизнес эрхлэгчдэд шинээр бичил болон жижиг дунд бизнес эхлүүлэхэд эхний хөрөнгө оруулалт хийх болон одоогийн бизнесээ өргөжүүлэн тэлэхэд шаардлагатай байгаа хөрөнгийг худалдан авахад туслах зорилготой Оюу Толгой ХХК-ийн боловсруулсан хөтөлбөр
- **Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгох:** Оюу Толгой ХХК, Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан гэрээний дагуу Оюу Толгой ХХК-аас (боломжтой бол) Өмнөговь аймгийн бүс дэх нийлүүлэгчдэд эхний ээлжийн давуу эрх олгох, дараагаар нь Монгол дахь нийлүүлэгчдэд доор заасан дэс дараалал болон тодорхойлолтын дагуу давуу эрх олгох тухай тохирсон тохиролцоо:
  - **Өмнөговийн нийлүүлэгч:** Өмнөговь аймагт бүртгэлтэй, тус аймагт бараа үйлдвэрлэдэг эсвэл нийлүүлдэг, эсвэл үйлчилгээ үзүүлдэг, мөн аж ахуйн нэгжийн 50-иас дээш хувийг Монгол улсын иргэн эзэмшдэг, нийт үндсэн ажиллагсдын 75%-иас дээш нь Өмнөговь аймагт амьдарч ажилладаг Монгол улсын иргэд байх, мөн түүнчлэн аж ахуйн нэгжийн төв болон салбар нь Өмнөговь аймагт бүртгэгдсэн, тухайн салбар нь Оюу Толгой ХХК-тай гэрээлэн харьцаж ажилладаг байх шаардлагуудыг хангасан нийлүүлэгчийг

ойлгоно.

- **Үндэсний нийлүүлэгч:** Монгол улсад бүртгэлтэй, компаний 50-иас дээш хувийг Монгол улсын иргэн эзэмшдэг байх шаардлагыг хангасан нийлүүлэгчдийг ойлгоно.
- **Гадаадын нийлүүлэгч Ангилал 1:** Монгол улсад бүртгэлтэй, татвар төлдөг, компанийн төв алба нь Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, нийлүүлж байгаа бараа үйлчилгээндээ Монгол улсын нутаг дэвсгэр дээр нэмүү өртөг бий болгосон, нийт ажиллагсдын 75-аас дээш хувь нь Монгол улсын иргэд байх шаардлагыг хангасан нийлүүлэгчийг ойлгоно.
- **Гадаадын нийлүүлэгч Ангилал 2:** Монгол улсад бүртгэлтэй ба татвар төлдөг нийлүүлэгчийг ойлгоно.
- **Гадаадын нийлүүлэгч Ангилал 3:** Дээр дурдсан шаардлагыг хангахгүй нийлүүлэгчийг ойлгоно.
- **Төслийн менежмент, барилга угсралтын компани:** 1, 2-р үе шат бүхий хөрөнгө оруулалтын томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх зорилгоор байгуулсан, Оюу Толгой ХХК-аас батламжилсан компани. Энэ нь уурхайн талбайг бүрэн хэмжээнд бүтээн байгуулахад шаардлагатай өргөтгөл, томоохон хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт чадавхи, чадварыг оруулж ирэхийн сацуу хийж буй бизнесийн түр шинжтэй нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ юм. Ажлын цар хүрээ нь уурхайн талбай дахь үйл ажиллагаанд чирэгдэл учруулалгүйгээр тодорхой хугацаанд хийж гүйцэтгэх инженерийн зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажлыг хамрах ба хөрөнгийн өргөтгөлийн (капиталжуулах) хөтөлбөрийн хүрээнд тодорхойлогдоно. Үүнд: Энэ компани нь Оюу Толгой ХХК-аас тогтоосон зөвшөөрөл олгох удирдамжийн дагуу ажиллах бөгөөд 100,000 ам. доллараас илүү дүнтэй худалдан авалтанд Оюу Толгой ХХК-ийн төлөөлөгчийн хамтаар гарын үсэг зурж баталгаажуулна.
- **Худалдан авалтын гэрээний төлөвлөгөө:** Худалдан авалтын төрлөөр нь зарцуулалтыг урьдчилан тооцож харах боломж олгосон зохион байгуулалт бүхий мэдээллийн сан. Үүнийг ашигласнаар дотоодын аж ахуйн нэгжүүдэд үүсэх боломжийг урьдчилан харж тооцох, хамгийн чухал, тулгамдсан захиалгад хуваарилах эх үүсвэрийг тогтоох мөн Оюу Толгой ХХК-ийн зарцуулалтын шаардлагын дагуу хийх боломжтой.
- **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль:** Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр худалдан авалт хийхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулах Монгол Улсын хууль.
- **Худалдан авах захиалга:** Тодорхойлолт/Үндсэн үзүүлэлт, тоо хэмжээг нь зааж, бараа нийлүүлэх/үйлчилгээ үзүүлэх талаар хүсэлт гаргаж буй арилжааны баримт бичиг. Байгууллагын нөөцийг төлөвлөх систем буюу програм хангамж ашиглан боловсруулдаг.
- **Нийлүүлэгчдийн үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:** Сонгон шалгаруулалтын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангаж, улмаар түүнд оролцох боломжтой, Оюу Толгой ХХК-ийн Нийлүүлэгчдийн мэдээллийн санд өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад оролцох



чадвартай, эрх бүхий гэж бүртгэгдсэн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж.

- **Гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж:** Оюу Толгой ХХК нь өрсөлдөөнт тендер шалгаруулалтын (ЭМААБО, туршлага, ажлыг хугацаанд нь бүрэн биелүүлэх, чанар, гэрээний нөхцөлийг хангаж буй байдал гэх мэт сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзсэний) үр дүнд хамгийн сайн гэж шалгарсан нийлүүлэгчид хамтран ажиллах санал буюу гэрээ байгуулах эрх олгоно. Эхний ээлжинд Өмнөговийн нийлүүлэгчдэд давуу эрх олгож, дараа нь Монголын нийлүүлэгчдэд давуу эрх олгоно. Гадаадын нийлүүлэгч шалгарсан тохиолдолд, Оюу Толгой ХХК нь үндсэн нийлүүлэгчтэй хамтран дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутагт өгөх үр өгөөжийг дээшлүүлэх боломжийг эрж хайн ажиллах болно.
- **Санал ирүүлэх хүсэлт:** Ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөл, шаардагдах тоо хэмжээ, тодорхойлолтыг тухайн ашиглалтын талбайн талаарх тодорхой мэдээллийн хамтаар өгч, нийлүүлэгчийг үнийн санал ирүүлэхийг хүссэн албан ёсны тендерийн баримт бичиг бөгөөд тухайн саналаа ирүүлсэн нийлүүлэгч нь бүртгэлд хамрагдсан, үнэлгээний үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан, тохиолдолд гэрээ байгуулах эрх олгож болох тухай заасан байна.
- **Үнийн саналд өөрчлөлт оруулах эрх:** ХААБ 06: Өмнөговийн нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх бодлого, ХААБ 07: Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх бодлогод заасан тодорхой нөхцөл байдалд Оюу Толгой ХХК-аас тендерийн үнийн саналдаа өөрчлөлт оруулах боломжийг тодорхой шалгуур үзүүлэлтийг хангасан нийлүүлэгчдэд олгохыг хэлнэ.
- **Тэтгэлэгт хөтөлбөр:** Уул уурхайн салбартай холбоотой чиглэлээр суралцаж буй оюутнуудад олгох тэтгэлэг буюу санхүүгийн дэмжлэг.
- **Ажлын цар хүрээ (Тодорхойлолт):** Шаардлагатай бараа, үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт (техникийн эсхүл инженерийн зураг төслийн дагуу тодорхойлолт).
- **Санхүүгийн ач холбогдол бүхий хүү:** Ерөнхийдөө, мөн энэхүү баримт бичгийн бусад хэсэгт заасанчлан 100,000 ам. доллар буюу түүнээс бага хэмжээний өртөгтэй хүү эсхүл үндэсний аль нэг хөрөнгийн биржэд бүртгэлтэй аж ахуйн нэгжээс гаргасан буюу шууд арилжаалсан хувьцааны 1% буюу түүнээс бага хэмжээний хүүг санхүүгийн ач холбогдол бүхий хүү гэж үзэхгүй. Үүний адилаар, тухайн зээл авч буй үеийн хэвийн хэмжээний хүүтэйгээр санхүүгийн байгууллагаас авсан хүүтэй зээлийг томоохон хэмжээний буюу ач холбогдол бүхий гэж үзэхгүй. Олон нийтэд арилжаалсан хувьцааны бус байдлаар тооцогдсон аливаа хүүг томоохон хэмжээний гэж үзнэ.
- **Шууд худалдан авалтын маягт:** Өрсөлдөөнт сонгон шалгаруулалт явуулалгүйгээр бараа, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж байгаа бол Оюу Толгой ХХК Зарцуулалтын зөвшөөрөл олгох матрицын дагуу албан ёсоор гарын үсэг зурж баталгаажуулахад шаардагддаг маягт. Тухайн маягтад энэ аргыг ашиглах нөхцөл, байдлыг хатуу чанд заасан байдаг бөгөөд үүнийг холбогдох албан тушаалтанаар батлуулах шаардлагатай.
- **Худалдан авалтын төрлийн ангилал:** Эх үүсвэрийг нь тогтоох, тэдгээрийг зохих байдлаар төлөвлөх, нөөцлөх, хөгжүүлэх зорилгоор

Оюу Толгой ХХК үйл ажиллагааны зардлыг ижил төстэй төрөлд ангилан хуваадаг. Тухайлбал, хүнд даацын хөдөлгөөнт машин механизм (ХДХММ) гэх мэтийн төрөлд хуваасны дараа, тус нэр төрлийг үйл ажиллагааны ач холбогдол, бизнест нөлөөлөх байдлаар нь хэд хэдэн ангилалд хуваадаг. Үйл ажиллагааны хувьд Хүнд даацын хөдөлгөөнт машин механизмыг Ангилал 1 – нэн чухал хэмээх ангилалд авч үзсэн байна.

- **Ангилал 1:** Үйл ажиллагаанд нэн чухал шаардлагатай худалдан авалтын төрөл. Тухайлбал, хөдөлгөөнт хүнд даацын машин механизм, төслийн талбай дахь эрчим хүч, тэсрэх бодис, гүний уурхайн малталт, дизель түлш зэрэг багтана.
- **Ангилал 2:** Үйл ажиллагааны бүтээмжид чухал нөлөө үзүүлэх, стратегийн ач холбогдол бүхий худалдан авалтын төрөл. Тухайлбал, хөдөлгөөнт хүнд даацын машин механизмын дугуй, авто тээвэр, өрөмдлөгийн ажил, баяжуулах үйлдвэрийн химийн бодис зэрэг орно.
- **Ангилал 3:** Хуримтлуулж, нөхөж болох худалдан авалтын төрөл. Тухайлбал, харилцаа холбоо, барилгын түрээс, төслийн талбай дах нийтийн хоол, өрмийн хошуу, байрлахтай холбоотой гарах зарцуулалт зэрэг багтана.
- **Ангилал 4:** Өдөр тутам өргөн хэрэглэх худалдан авалтын төрөл. Тухайлбал бичиг хэргийн хангамж, албан тасалгааны тоног төхөөрөмж, аюулгүй байдал хөдөлмөр хамгааллын хангамж, нэн чухал бус засвар үйлчилгээний хэрэглэгдэхүүн зэрэг багтана.
- **Зардал кодлох стандарт ангилал (ЗКСА):** дэлхийн хэмжээний жишиг үзүүлэлтийг хэр хангаж байгааг тодорхойлохоор Оюу Толгой ХХК-ийн ашигладаг төрөлжүүлэлтийн програм. Уул уурхайн салбарт хамаарах 200 гаруй төрлийн зардал кодолсон стандарт ангилал байдаг.
- **Туслан гүйцэтгэгч ажиллуулах үүрэг:** Оюу Толгой ХХК-ийн өмнө хүлээсэн үндсэн гүйцэтгэгчийн үүргийн дагуу Монгол Улсын дотоодын аж ахуйн нэгжийг туслан гүйцэтгэгчээр ажиллуулахаар гадаадын нийлүүлэгчдэд тавьсан шаардлага.
- **Тендерт оролцогч нийлүүлэгчдийн жагсаалт-бүртгэл:** Хэмжиж болохуйц байдлаар зохион байгуулсан урьдчилсан сонголтын дүнд нийлүүлэгчдийг бараа материал хангах, үйлчилгээ үзүүлэх чадвараар нь үнэлсэн албан ёсны бүртгэл, товч мэдээлэл.
- **Нийлүүлэгчдийг хөгжүүлэх төлөвлөгөө:** Оюу Толгой ХХК-ийн нийлүүлэгчдийг үнэлж шалгаруулах явцад олж тогтоосон чадварын шаардлагын (ЭМААБО, санхүү, ёс зүй, Хүний нөөцийн удирдлага, хууль эрх зүй гэх мэт) дутмаг, хангалтгүй байдлыг арилгахаар Оюу Толгой ХХК-аас тусгайлан боловсруулсан төлөвлөгөө.
- **Нийлүүлэгчдийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх:** ЭМААБО, санхүү, ёс зүй, дотоодын аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх, хууль эрх зүй, мэдээллийн аюулгүй байдал, чанарын удирдлага, хүний нөөцийн удирдлага, үйлчилгээ, лавлагаа зэрэг Оюу Толгой ХХК-ийн үндсэн шалгуур үзүүлэлтийг (одоогоор хамтран ажиллаж байгаа) нийлүүлэгч нар хангаж байгаа эсэхийг үнэлж, шалгаруулдаг үйл явц. **Нийлүүлэгчид:** Тус бодлогын баримт бичгийн хүрээнд “Нийлүүлэгч” гэж зөвхөн бараа нийлүүлэгчид бус харин зөвлөхүүд, тээврийн компани, инженер, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч, санхүүгийн

байгууллага, тоног төхөөрөмж түрээслүүлэгч зэрэг байгууллагуудыг хамруулан авч үзнэ.

- **Техникийн ур чадвар дамжуулах боломж:** Техникийн ур чадварыг Монгол Улсын иргэдэд дамжуулах боломж.
- **Сургах үүрэг амлалт/хариуцлага:** Харилцан ойлголцлын санамж бичигт тусгагдсаны дагуу Оюу Толгой ХХК-ийн стратегийн түншүүд Монгол ажилтнуудыг сургах, ур чадвараа дамжуулах үүрэг амлалт.

